



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

### “Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1025 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор “Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд Налайх дүүргийн 6-р хороо Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар болон Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 63,056,000 (жаран гурван сая тавин зургаан мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг зохион байгуулах, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

**“УЛААНБААТАР ОЛОН УЛСЫН ЯВГАН АЯЛЛЫН ФЕСТИВАЛЬ”  
 АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
 ШААРДАГДАХ ЗАРДАЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз хөгжим техник түрээс (4x3 хэмжээтэй) Тэрэлж	Багц 3 өдөр	13,000,000	13,000,000
2	Хөтлөгчийн зардал	Багц 3 өдөр	500,000	1,500,000
3	Маркетинг сурталчилгааны зардал	Багц 7 өдөр	2,000,000	2,000,000
4	Хэвлэлийн зардал (анонс эх бэлтгэл, маршрутын танилцуулга, туг)	Багц	3,000,000	3,000,000
5	Урлагийн тоглолт зохион байгуулах	Багц 3 өдөр	2,000,000	6,000,000
6	Алхалтын батламж (оролцогчдод)	250 ш	5,000	1,250,000
7	Гадаад зочдын зочид буудлын зардал	6 хүн 4 өдөр	295 000* 6 хүн 4 өдөр	7,080,000
8	Гадаад зочдын тээврийн зардал	4 өдөр*2	750,000	6,000,000
9	Морин циркийн үзүүлбэр	1 өдөр	5,000,000	5,000,000
10	Гадаад зочдын хоолны зардал	12 хүн 4 өдөр	150,000	7,200,000
11	Асар 5*5м	Зөдөр 5ш	180,000	2,700,000
12	Тээврийн зардал (Урал-31, УАЗ-469)	4 удаа	750,000	3,000,000
13	Био зөөврийн 00	10ш	322,600	3,226,000
14	Зөөврийн цахилгаан үүсгүүр түрээс	Зөдөр	700,000	2,100,000
Нийт дүн				63,056,000